

ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
04 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

2023.04.28

Хавирга

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны захирамжийн дагуу ажлын хэсгийг сумын засаг даргын А/33 дугаар захирамжаар томилсон.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг тогтмол гарган өгч байна.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

Сарын төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгсөн.

Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:

Тамгын газрын мэргэжилтнүүдээс иргэдэд хууль эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг хүргэх төлөвлөгөө гарган 7 хоног бүр өөрсдийн чиглэлийн хууль, тогтоол, журамаар мэдээлэл бэлтгэн тамгын газрын цахим хуудас, сумын олон нийтийн зарын группээр хүргэсэн./9 мэргэжилтэнг хамруулсан/

Засаг даргын тамгын газар, цагдаагийн хэсэг, ЕБС хамтран ахлах ангийн сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цахим гэмт хэргээс өөрийгөө хамгаалах сургалтыг хамтран зохион байгуулсан./98 сурагч хамрагдсан/

Албан хэрэг хөтлөлтийг Монгол бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангахаар Төрийн албан хаагчдаас Монгол бичгийн мэдлэгийн түвшин тогтоох шалгалт авсан.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Сумын хамтарсан багийн хуралдааныг 1 удаа зохион байгуулж, хүүхэд хамгаалалын талаарх авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцсэн.

Ерөнхий боловсролын багш нарын ур чадварын уралдааны I, II дугаар шатыг зохион байгуулсан.

Мөн “Стем боловсрол” уралдааны I шатыг зохион байгуулсан.

Сумын засаг даргын захирамжаар 04 дүгээр сарын 21-нд Хамтарсан баг, ЕБС хамтран хүүхдийн III чуулганыг “Оролцоотой хүүхэд хөгжиж, хөгжсөн хүүхэд хамгаалагддаг” нэртэйгээр зохион байгуулсан. /Чуулганд 50 хүүхэд оролцсон/

Соёлын төвийн дэргэдэх “Үүлэн” бүжгийн дугуйлан нь 04 дүгээр сарын 11-ээс 23 хүүхэдтэй хичээллэж эхэлсэн, сургалтыг мэргэжлийн 2 багш урьж зохион байгуулж байна.

Цэцэрлэгээс байгууллагын 60 жилийн ой угтсан ажлын хүрээнд “Нэг бүлэг нэг шинэлэг сургалтын төв” үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулсан.

Хүүхдийн салбар цэцэрлэгийн сургачдад Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс 04 дүгээр сарын 12-ны өдөр “Цагаан хоолны өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулж, мөн хүүхэд бүрт шар будааны дэр, сургалтын хэрэглэгдэхүүн хүлээлгэн өгөв. Мөн салбар цэцэрлэгийн эцэг, эхчүүд санаачлан тохижилт, засварын ажил хийж хүүхэд сурах орчин нөхцлийг сайжруулах ажлыг зохион байгуулсан.

“Дэлхийн номын баярын өдөр”-өөр соёлын төвөөс дараах арга хэмжээг зохион байгуулав.

- Соёлын төвөөс санаачлан хүүхдийн цэцэрлэгийн бага “А” бүлэгт “Үнэг чоно хоёр” үлгэрийг дүрийн тоглолтоор хүргэсэн.

- ЕБС-ийн сурагчдын дунд “ номын тэмдэглэл хөтлөх уралдаан”-ыг англи хэлний багш нартай хамтран зохион байгуулав.

- Зөөврийн номын сангийн үйлчилгээг ЗДТГ-т ажиллуулж, соёлын өвийн ажилтан “Угийн бичиг”-ийн сургалт явуулсан.

Соёлын төвөөс ахлах ангийн сурагчдын авьяасыг нээх зорилгоор “Open mic” арга хэмжээг зохион байгуулсан.

“Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны нээлтийн арга хэмжээг соёлын төв, ЭМТ хамтран зохион байгуулж, иргэд, төрийн албан хаагчдад сургалт, мэдээлэл хүргэж, арга хэмжээнд оролцсон иргэдийн биеийн жингийн индексийг тодорхойлж өгч, зөвөлгөө өгсөн.

“Энэ жилдээ эрүүл жиндээ” аяны хүрээнд байгууллага, ААН бүрээс зохион байгуулах ажлын төлөвлөгөөг гаргаж хуваарийн дагуу төрийн албан хаагчид, ААН-ийн ажилчдыг өглөөний гүйлт, дасгалд хамруулж байна.

Эрүүл мэндийн төв магадлан итгэмжлэлийн шалгалтанд орсон.

Залуучуудын холбооноос залуу малчин 10 өрхөд хаврын мал төлөлтийн ажилд дэмжлэг үзүүлэн “Залуу малчдаа дэмжье” ажлыг зохион байгуулж, хүнс, эд материалын дэмжлэг үзүүлсэн.

Залуучуудын холбооноос төрийн байгууллага, ААН, багуудын дунд шилжин явах цомын “Гар бөмбөг”-ийн тэмцээнийг зохион байгуулсан.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Мал эмнэлгийн тасгаас шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын татан авч, тарилга хийх бэлтгэл хангасан.

Малд хаврын ангилан, ялгалт хийх, хилийн зурваст нутагладаг малчин өрхийн үхэрийг ээмэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан.

МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН С.АЗБИЛЭГ